



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 07/21

Мандалговь

“Хоббизоон” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Ижий.gov” төсөл хөтөлбөр /Дундговь/-ийн гүйцэтгэгчээр шалгарсан “Хоббизоон” ХХК-тай 997,455,118 (есөн зуун ерэн долоон сая дөрвөн зуун тавин таван мянга нэг зуун арван найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Тоног төхөөрөмжийг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Хоббизоон” ХХК-ний захирал (Г.Төгөлдөр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150151